



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 30 өдөр


Дугаар А/330

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөст, Зэрэг, Дуут сумдын ойн баярт дурсамж хийлгэсэн зардалд 180,000 төгрөг (нэг зуун наян мянга), Төрийн дээд шагнал гардуулах үйл ажиллагааны зардалд 403,075 төгрөг (дөрвөн зуун гурван мянга далан тав), Дэлхийн банкны Монгол улсыг хариуцсан менежер бөгөөд суурин төлөөлөгч Андрей Михнев тэргүүтэй төлөөлөгчидтэй цаашид манай аймагт хамтран хэрэгжүүлж болох төсөл хөтөлбөрийн талаар хийсэн уулзалт арга хэмжээний зардалд 2,074,950 (хоёр сая далан дөрвөн мянга есэн зуун тавь), TEDxKhovd арга хэмжээний зардалд 583,950 төгрөг (таван зуун наян гурван мянга есэн зуун тавь)-ийг тус тус зарцуулсугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 3,241,975 төгрөг (Гурван сая хоёр зуун дөчин нэгэн мянга есөн зуун далан тавь)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.



Б ДҮГЭРЖАВ

Zah A/330 Bo

8400 01 2774